

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2023 ОНЫ  
08 ДУГААР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

**НЭГ. УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД**

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, аймгийн Засаг даргаас 5 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг тооцон ажилласан.

“Нүүдэлчин Монгол 2023” дэлхийн соёлын фестиваль 2023 оны 08 дугаар сарын 18-аас 20-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, Говьсүмбэр аймгийн Засаг даргын Тамгын газар, Шивээговь, Баянтал, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар, Соёл урлагийн газар, Соёлын Төвүүд, Боржигин чуулгын хамт олон болон Соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч нийт 75 хүний бүрэлдэхүүнтэй Боржигин өв соёлыг гадаад, дотоодын иргэд болон жуулчдад сурталчлан таниулсан.

Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын үүргийн дагуу ой хээрийн гал түймрийг унтраах бүлгийн багаж зэвсэглэмж болон аврах ажиллагааны бэлтгэл, бэлэн байдал, хэвийн ажиллагааг 2023 оны 8 дугаар сарын 02-ны өдөр шалгаж, бэлтгэл бэлэн байдлыг хамруулсан.

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- Ногоон бүсийн айл өрх, жуулчны бааз, амралтын газрын барилга байгууламжид гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, стандарт, Гал түймрийн улсын хяналтын дүрэм, галын аюулгүй байдлын норм, нормативын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах” хяналт, шалгалтыг 2023 оны 8 дугаар сарын 07-нд, Боловсролын байгууллагын барилга байгууламжийг 8 дугаар сарын 14-ны өдрөөс төлөвлөгөөт хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж шалгалтад хамрагдсан иргэн, хуулийн этгээд, ААНБ-8, илрүүлсэн зөрчил давхардсан тоогоор-62, газар дээр нь төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрсэн 7 зөрчлийг арилгуулах талаар заавар зөвлөмж өгч, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн албан шаардлага 8-ыг хүргүүлж, Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газарт заасан хугацаанд [disaster\\_inspector@nema.gov.mn](mailto:disaster_inspector@nema.gov.mn) цахим хаягаар хүргүүлсэн.
- Онцгой байдлын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд Сүмбэр сумын 3 дугаар багийн орон сууцнуудад гал түймэр, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх үзлэг шалгалтыг зохион байгуулж ажиллаж байна.

Онцгой байдлын ерөнхий газар болон Ус, Цаг уур орчин шинжилгээний газраас ирүүлсэн цаг агаарын сэрэмжлүүлэг мэдээ 32, Онцгой байдлын газрын үйл ажиллагааны чиглэлээр 5, Үер уснаас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг мэдээ 67 нийт 104 удаагийн мэдээг Онцгой байдлын газрын болон “www.go.nema.gov.mn” сайтад байршуулж “Чойрын зар”, “Боржигин нутаг минь”, “Шивээговь нэгдсэн зарын групп”, “Говьсүмбэр аймаг” “www.govisumber.gov.mn”,

“Govisumbernews.mn” гэсэн хаягуудад шейрлэж иргэдэд хүргэн ажилласан. “Go.nema.gov.mn” сайтад 2023 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн байдлаар 35072 хандалт хийгдсэн байна.

Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх 004 дугаарын тусгай зөвшөөрөлтэй “Гамшгаас хамгаалах судалгаа шинжилгээний төв” ТББ-аас ирүүлсэн Говьсүмбэр аймгийн Баянтал сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг “Страто” ХХК-ийн нүүрс угаан баяжуулах үйлдвэрийн гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээнд анхан шатны хяналт шинжилгээ хийж Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн эрсдэлийн удирдлагын газарт албан бичгээр хүргүүлсэн.

ОХУ-аас БНХАУ-тай хийн дамжуулах хоолойн маршрутын дагуу Баянтал суманд ачилт буулгалтын талбай байгуулах ажлын хэсэг Баянтал суманд ажиллан судалгаа хийж, харилцан мэдээлэл солилцож, шаардлагатай мэдээллийг өгсөн.

### **ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, орлого бүрдүүлэлтийг эрчимжүүлэн төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаж байна.

2023 оны 08 дугаар сарын нийт татварын орлогын төлөвлөгөө 7 424 001 мянган төгрөг гүйцэтгэлээр 8 063 923 мянган төгрөг буюу 108.6%, үүнээс Улсын төсвийн орлогын төлөвлөгөө 1 106 524 мянган төгрөг гүйцэтгэлээр 1 309 871 мянган төгрөг буюу 118% гүйцэтгэлтэй байна. Сумын төсвийн орлогын төлөвлөгөө 4 529 107 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4 954 652 мянган төгрөг буюу 109%, аймгийн төсвийн орлогын төлөвлөгөө 1 788 370 мянган төгрөг төвлөрүүлэхээс 1 799 400 мянган төгрөг буюу 100.6%-ийн хүлээгдэж буй гүйцэтгэлтэй байна.

Татвар төлөгчдийн бүртгэлийг сайжруулж, татварын бааз суурийг нэмэгдүүлэх хүрээнд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар 698 хуулийн этгээд бүртгэлтэй байсан бол 2023 оны 08 сарын 23-ны байдлаар 707 болж өссөн. Татвар төлөгчдийн хариуцлагын хэлбэрээр харуулбал: Үүнд: ХК-1, ХХК-370, ББН -5, ЗБН -11, Хоршоо -31, ХЗХоршоо- 1, ОНӨҮГ-6, Салбар-66, төсөвт болон төрийн бус байгууллага, сан ОНБ – 216 байна.

#### **Санхүүгийн хяналт аудитын алба:**

Санхүүгийн хяналт шалгалтыг төлөвлөгөөт 7, төлөвлөгөөт бус 3 нийт 10 байгууллагад хийж 287.870,8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 11141,0 мянган төгрөгийг орон нутгийн орлого болгуулахаар, 7.212,2 мянган төгрөгийг хувь хүнд нь буцаан олгуулахаар, улсын төсөвт төвлөрүүлэхээр 12.016,8 мянган төгрөг нийт 30.370,0 мянган төгрөгийн улсын ахлах байцаагчийн нөхөн төлбөрийн акт тогтоож 18.971,3 мянган төгрөгийг зөрчилийг хуулийн байгууллагаар шийдвэрлүүлэхээр шилжүүлсэн. Мөн 12.224,6 мянган төгрөгийн зөрчлийг арилгуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлж, актын барагдуулалт 47,2 хувь. Нийт тогтоосон нөхөн төлбөрийн актаас 14.361,8 мянган төгрөгийн акт барагдсан, 16008.2 мянган төгрөгийн актын барагдуулах хугацаа нь болоогүй байна. 226.234,9 мянган төгрөгийн зөрчилийг арилгуулахаар зөвлөмж өгч ажиллалаа

Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасны дагуу аймгийн төсөвт, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нийт 43 байгууллагын шилэн дансны мэдээллийг цахим хуудсанд үнэн зөв болон цаг хугацаандаа оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг. 8 дугаар сарын шилэн дансны мэдээ оруулалтын байдал 97.7 хувьтай, энэ нь өмнөх сараас 2.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## **ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

### **Эрх зүйн сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:**

Аймгийн Засаг даргын Тамгын газраас “Хөдөлмөрийн тухай хууль-Ээлжийн амралт эдлэх эрх хэрхэн үүсэх, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Иргэний хууль-Гээгдэл эд хөрөнгө” мэдээлэл бэлтгэж, Зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх “Нэг зам Нэг соёл” арга хэмжээг цахимаар сурталчилан таниулах, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх АА бүлгэмийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилж мэдээллийг нийт давхардсан тоогоор 351 хүнд мэдээллийг хүргэсэн.

**Архивын тасаг:** Архивийн баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 2 хөмрөгийн 16 хадгаламжийн нэгжийн 837 хуудас, 437 заалт, 2637 хүний нэр, 437 байгууллагын нэр, 1306 газар зүйн нэр, 1900 потошоф, 1900 скайнер, 837 холболт хийж ажилласан.

2023 оны 08 дугаар сард 48 иргэнд лавлагаа гаргаж үйлчилгээ үзүүлсэн.

## **УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС**

### **Иргэний бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр гадаад паспорт захиалсан - 376
- Иргэний үнэмлэх шинээр олгосон - 91
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо – 32
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 1
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -2
- Үрчлэлтийн бүртгэлийн тоо - 0
- Овог, нэр өөрчлөлтийн бүртгэлийн тоо - 4
- Эцэг тогтоолтын бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо -7
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн - 22
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо - 10
- Тоон гарын үсэг олголт - 22

**Нийт - 568**

### **Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:**

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 8

- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 9
- Гэрээний бүртгэл - 59
- Барьцааны гэрээний бүртгэл - 185
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга - 3

**Нийт - 264**

**Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:**

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 2
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -7
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл -

**Нийт - 9**

**Архивын чиглэлээр:**

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар - 33
- Хуулийн этгээдэд гаргасан лавлагаа, хуулбар - 0
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар - 825

**Нийт- 858**

**Нийт үзүүлсэн үйлчилгээ – 1699**

**ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ХҮРЭЭНД**

Тус алба нь хэргийн газрын үзлэгт- 13 үүнээс хүний амь нас хохирсон-3, хүний эрүүл мэндэд хохирол учруулсан-0, хулгайлах гэмт хэрэг-1, дээрэмдэх-0, зам тээврийн осол-4, эд хөрөнгө устгах гэмтээх-0, бусад-5. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа, хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 335 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг-12, үүнээс хүнд-1, хүндэвтэр-0, хөнгөн-5, гэмтлийн зэрэгт хамаарахгүй-4, гэмтэл тогтоогдоогүй-2, цогцост хийсэн шинжилгээний тоо-2.

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ГАЗАР**

**Удирдлага зохион байгуулалтын чиглэлээр**

1. Байгууллагын үйл ажиллагааг иргэд, олон нийтэд сурталчлан, таниулах зорилгоор “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 13:00 цагаас 16:00 цагийн хооронд аймгийн Биеийн тамир, спортын хорооны гадна талбайд зохион байгуулж, 56 иргэнд хамрагдаж мэдээлэл авсан байна.үйлчилгээ үзүүлсэн.
2. Тайлант хугацаанд нийт 6 хоригдолтой “Нийгмийн ажлын үйлчилгээний гэрээ” байгуулж, “Хорих ял эдлэх үеийн жишиг хөтөлбөр”-ийн дагуу нийгэмшүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажилласан.

3. 2023 оны 08 дугаар сарын байдлаар 130 хоригдол ар гэрийн хүсэлтийн дагуу цахим уулзалтад хамрагдсан байна. Цахим уулзалт хийсэн хоригдлын тоог урьд оны мөн үетэй харьцуулахад 47-оор нэмэгдэж 36,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
4. 0425 радио, телевизийн “Хуулийн цаг” булангаар “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”, “Зөрчлийн тухай” хуулиудын холбогдох хэсгээр болон “Хорих ангийн дотоод журам”, “Хяналтын хуудас ашиглах журам”, “Албан хаагчийн аюулгүйн тойрог тогтоох журам”, “Аюулгүй ажиллагааны зааварчилгаа” зэрэг сэдвээр цахим сургалтыг өдөр бүрийн 10<sup>00</sup>–11<sup>20</sup>, 13<sup>30</sup>–15<sup>00</sup> цагийн хооронд тогтмол зохион байгуулан хэвшүүлж нөлөөллийн арга хэмжээг тасралтгүй авч ажиллаж байна.
5. Тайлант хугацаанд суллахад бэлтгэх хөтөлбөрийн хүрээнд суллагдах дөхсөн хоригдлуудыг холбогдох сургалтад хамруулж, суллагдсаны дараа 8 хоригдлыг “малчин”, “хувийн компанид туслах ажилтан” гэх зэрэг ажлын байранд зуучилсан.
6. 3 хоригдлын 291,020 төгрөг, хөдөлмөрийн хөлснөөс нийт 4 хоригдлын 1,857,100 төгрөг нийт 2,148,120 төгрөгийн хохирол төлбөрийн харъяа шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дансанд шилжүүлэн хэсэгчлэн төлөлт хийсэн.
7. Хорих ангид сувилагч нар амбулаторын үзлэгээр давхардсан тоогоор 312 хоригдол, давтан үзлэгт 211 хоригдол, эмчийн хяналтад байгаа 4 хоригдолд давхардсан тоогоор 125 удаагийн үзлэг хийж эмчийн жороор эм олгож, зөвлөгөө өгч ажиллалаа.
8. 2023 оны 08 дугаар сарын 04-ний өдөр 4 хоригдол, 08 дугаар сарын 07-ны өдөр 5 хоригдол, нийт 9 хоригдолд “Үндсэн хуулийн 2 дугаар бүлэг”, “Эрүүгийн хуулийн 5 дугаар бүлэг”, “ШШГТХ-ийн 21 дүгээр бүлэг”, “Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлэг”, “Хорих ангийн дотоод журам”, “Хяналтын хуудас хэрэглэх журам”, “Аюулгүйн тойрог тогтоох журам”, “Дасан зохицох чадвар суулгах”, “Харилцаанд үүсэх зөрчил”, “Биеэ авч явах байдал”, “Хандлагаа өөрчлөх нь” зэрэг 12 сэдвээр 2 удаагийн давтамжтай нийт 24 цагийн сургалтыг зохион байгуулсан. “Эрх зүйн” сургалтын гарын авлага бэлтгэж сургалтад ашиглаж байна.
9. Хоригдлын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, авъяас чадварыг нээн хөгжүүлэх зорилгоор гитар хөгжмийн дугуйланд 10 хоригдол, морин хуурын дугуйланд 10 хоригдол, шагайн харваан дугуйланд 34 хоригдол, шатар, даамны дугуйланд 40 хоригдол, ширээний теннисний дугуйланд 8 хоригдол хамрагдаж байгаа бөгөөд сургалтын бүсийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, сэтгэн бодох чадварыг сайжруулах, хувь хүний хөгжлийг дээшлүүлэх зорилгоор зургийн дугуйланд 7 хоригдол, шигтгээн наамлын дугуйланд 5 хоригдол, оёдлын дугуйланд 2 хоригдол, гар урлалын дугуйланд 6 хоригдол хамруулж дугуйлангийн үйл ажиллагааг идэвхжүүлэн ажиллаж байна.
10. “Олон улсын сэтгэлийн боловсролын төв”-ийн Говьсүмбэр аймгийн салбарын багш Д.Мөнхтуул 2023 оны 08 дугаар сарын 7, 14-ний даваа гарагт 1 цаг 30 минутын “Худал

бодол болон Хор хөнөөлтэй бодол” сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулж сургалтад давхардсан тоогоор 115 хоригдол хамрагдсан байна.

11. Шүүхийн 2023 оны 08 дугаар сарын байдлаар 312 гүйцэтгэх баримт бичгийн 24441196,3 төгрөг, 137 гүйцэтгэх баримт бичгийн 6425723,2 төгрөгийг бодитой биелүүлж 165 гүйцэтгэх баримт бичгийн 18021992,4 төгрөгийн үлдэгдэлтэй байна. 2023 оны 08 дугаар сарын гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 47,1 % хувьтай ажиллаж байна.

### **ЦАГДААГИЙН ХЭЛТЭС**

Цагдаагийн хэлтэс нь Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 202/ “Гэмт хэрэг зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах” журамд заасны дагуу 2023 оны 08 дугаар /07.21-08.20/ сард иргэд, аж ахуйн нэгж байгууллагаас нийт 87 гомдол, мэдээлэл хүлээн авснаас гэмт хэргийн шинжтэй 13, зөрчлийн шинжтэй 74 гомдол мэдээлэл бүртгэгдлээ.

Тайлангийн хугацаанд зөрчил үйлдсэн 2344 иргэнийг эрх бүхий албан тушаалтнаас болон шүүхээс 88580500 төгрөгөөр торгож, согтуугаар зөрчил гаргасан 9 хүнийг саатуулж эрүүлжүүлэн, 8 хүнийг шүүхээр баривчлуулан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 25 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хассан байна.

Хариуцсан нутаг дэвсгэрийн эрүү, хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор давхардсан тоогоор худалдаа, үйлчилгээ эрхэлдэг 154 цэгийн үйл ажиллагаа, үйлчилгээний цагийн хуваарьт өдөр тутам хяналт шалгалт хийж, зөвлөгөө өгч ажиллав.

Сүмбэр сум, Баянтал сум, Шивээговь сумын нутаг дэвсгэрт давхардсан тоогоор 360 алба хаагч 2460 цагийн эргүүлийн үүрэг гүйцэтгэж, гудамж талбай, олон нийтийн газар зөрчил гаргасан 21 хүнийг 385000 төгрөгөөр торгосон.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх санамж, анхааруулга, зөвлөмж 54 видео шторк 48, бусад 29 нийт 131 мэдээллийг “Говьсүмбэр аймгийн цагдаагийн хэлтэс” пэйж хуудсанд байршуулж, иргэнд мэдээллийг хүргэсэн.

“Нэг зам-нэг соёл” нэгдсэн арга хэмжээг сурталчилж, Шивээговь сумын босоо тэнхлэгийн авто зам дагуу зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх постер бүхий 2 ширхэг самбарыг шинээр байршуулж, Баянтал суманд засмал замд ойролцоо мал бүхий иргэдийн бод малд гэрэл ойлгогчтой хүзүүвч зүүлгэж, малчдад зөвлөмж хүргүүлж нийгмийн хариуцлагын хүрээнд “Монгол даатгал”, “Төрийн банк” зэрэг байгууллагууд аяны үйл ажиллагаанд сайн дураар нэгдэж хамтран ажиллалаа.

Цагдаагийн ерөнхий газрын 2023 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн 5а/7703 дугаарын албан бичгээр ирүүлсэн “Насанд хүрээгүй хүнийг болзошгүй осол гэмтэл, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө” 14 хоногийн аяныг байгуулж, биелэлтийг Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлээ.

### **ДӨРӨВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

## **Боловсролын чиглэлээр:**

Сургууль, цэцэрлэгийн 2023-2024 оны хичээлийн жилийн бэлтгэл байдлыг хангаж, урсгал засварын 5 сургууль, 7 цэцэрлэгт хийсэн.

Цэцэрлэгийн багш, ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт 15-аас 20-ны өдрүүдэд нийт 75 багш ажилчид хамрагдсан.

2023-2024 оны хичээлийн жилийн цэцэрлэгийн хүүхдийн бүртгэл 8 дугаар сарын 22-оос эхэлж, нийт 496 хүүхэд бүртгэлд хамрагдсан.

Ерөнхий боловсролын сургуульд 1 дүгээр ангид элсэн суралцах хүүхдүүдийн бүртгэлийн EMongolia цахим системээр 8 дугаар сарын 15-аас хийж, нийт 416 хүүхэд бүртгүүлсэн.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны "2023 оныг сургалтын байгууллагын менежментийг сайжруулах жил болгон зарлах тухай" А/01 дүгээр тушаалыг хэрэгжүүлэх, 2023-2024 оны хичээлийн жилийн бэлтгэлийг хангах зорилгоор 2023 оны 08 дугаар сарын 23-аас 25-ны өдрүүдэд бүх шатны боловсролын сургалтын байгууллагын удирдлага, мэргэжилтнүүдийн сургалтад нийт 21 албан хаагч хамрагдаж байна.

## **Соёл, урлагийн чиглэлээр:**

Соёл урлагийн газраас "Монголын түүх, соёл, шинжлэх ухааны танин мэдэхүйн тухай 21 контенттэй VR BOX төхөөрөмжийг Боржигин өв музейд гардуулж иргэдэд орчин үеийн технологи бүхий шинэлэг үйлчилгээг үзүүлэх боломжийг бүрдүүллээ.

НҮҮДЭЛЧИН” Дэлхийн соёлын фестивальд Говьсүмбэр аймаг амжилттай оролцлоо

2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдөр хүртэл музейн танхимын үйлчилгээг нийт 42 иргэнд үзүүлсэн байна. Үүний 2 том хүн, 8 оюутан, 1 гэр бүл төлбөртэй үйлчлүүлж нийт 17000 төгрөгийн орлого төвлөрүүлж, 25 хүүхэд 6 том хүнд музейн танхимын үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.

Аймгийн музейгээс 2023 оны 8 дугаар сарын 01-ний өдөр Отгонтэнгэр их сургуулийн оюутан залуусыг тоглоом наадгайн боловсролын хөтөлбөрт хамруулан Монголын уламжлалт шагайн наадгай, Боржигин тоглоом наадгайн төрөл болох Аргай тонгорох тоглоомыг зааж сурган, сурталчлан ажиллалаа. Хөтөлбөрт нийт 8 оюутан хамрагдсан.

Аймгийн номын сангийн уншлагын танхимаар 128 иргэнд үйлчилгээ үзүүлсэн.

Өмнөговь аймагт "ДИНОЗАВР ФЕСТИВАЛЬ-2023" фестиваль 2023 оны 07 сарын 29, 30-нд Боржигин чуулга оролцож, Боржигин өв соёлоо сурталчлан оролцсон.

2023 оны 07 дугаар сарын 24-28-ны хооронд болсон Улсын аварга шалгаруулах боксын тэмцээнд 23 багийн 178 тамирчин орсноос Говьсүмбэр аймгийн 3 тамирчин оролцсон.

Монголын Жюү Жицүгийн холбоо Арахбын “АJP” холбоотой хамтран 5 дахь жилдээ зохион байгуулж буй “ULAANBAATAR INTERNATIONAL PRO” Олон улсын тэмцээн Монгол бөхийн өргөөнд 07 дугаар сарын 20,21-нд болсон. Тус тэмцээнд Говьсүмбэр аймгийн ..... тамирчин оролцсон.

2023 оны 08 дугаар сарын 19-ний өдөр Монгол Улсын Хошой мэргэн Т.Жаргалсайханы нэрэмжит үндэсний шагайн харваа тэмцээнд болж өндөрлөлөө. Уг тэмцээнд 20 багийн 160 гаруй харваачид оролцсон.

Монголын ахмад мастеруудын 7 дугаар Их наадамд Говьсүмбэр аймгаас 47 тамирчин оролцож нийт 4 алт, 5 хүрэл медаль хүртсэн.

### Эрүүл мэндийн талаар:

дд	Үзүүлэлт	2022 оны 08 сар	2023 оны 08-р сарын 20-ны байдлаар
1	Төрсөн эх	230	231
2	Гэрийн төрөлт	1	1
3	Амьд төрсөн хүүхэд	228	232
4	Амьгүй төрөлт	2	0
5	Нас баралт	57	49
6	Эмнэлгийн нас баралт	15	15
7	Эмнэлэгт хоног болоогүй нас баралт	6	4
8	0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	2
9	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	0
10	Эмнэлгээс гарсан хүний тоо	4267	3725
11	Амбулаторийн үзлэг	79910	76842
12	Халдварт өвчин	2509	233

“Ковид-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжаар олгосон 25,8 сая төгрөгийн үнэ бүхий 2 ширхэг спирометр болон дагалдах хэрэгслийг хүлээн авч хоёр Сумын эрүүл мэндийн төвд хүлээлгэн өгсөн.

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын эсрэг цар тахлын үеийн хариу арга хэмжээ, эрүүл мэндийн тогтолцооны бэлэн байдлын хүрээнд Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын тусламжаар нийлүүлэгдсэн 28,3 сая төгрөгийн өртөг бүхий эмнэлгийн хог хаягдлыг ариутгах автоклав төхөөрөмжийн иж бүрдэл нийт 5 ширхэгийг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн. Мөн эрүүл мэндийн газарт Автоклав-1, Суурийн компьютер-1, цахилгааны нөөц батарей-1, Хэмийн хяналтын нөөц дамжуулах төхөөрөмж-1 нийт 16,7 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн.

Бөөрний гемодиализийн аппарат ашиглалтад орж, 4 иргэнийг давхардсан тоогоор 51 удаагийн үйлчилгээг үзүүлээд байна.

### Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээ:



Тайлант хугацаанд 2019-2022 оны Хөдөлмөр эрхлэлтийгдэмжих хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгт хамрагдсан 149 иргэний эргэн төлөлтөд хяналт тавьж 49 хүний 10886,0 мян.төгрөгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлж ажилласан.

Түр ажлын байрыг дэмжих үйл ажиллагааны хүрээнд мод тарих арга хэмжээнд 27 иргэнийг хамруулж 10513,0 мян.төг, нийтийг хамарсан ажил арга хэмжээнд 22 иргэнийг хамруулж 8250,0 мян.төг, нийт 49 иргэнийг түр ажлын байраар хангаж 18763.0 мян,төг цалин олгож ажилласан.

**Нийгмийн халамжийн үйлчилгээ:**

2023 оны 08 дугаар сарын 17-ны байдлаар зорилтот бүлгийн иргэдэд нийгмийн халамжийн үйлчилгээг нийт 12180 иргэнд цаг тухайд нь олгож, түргэн шуурхай үйлчилсэн. Үүнд:

№	Үзүүлэлт	2023.01.01 2023.08.17
		Хүн тоо
1	Халамжийн тэтгэвэр	280
2	Нөхцөлт мөнгөн тэтгэмж	254
3	Амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж	242
4	Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	784
5	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	91
6	Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	142
7	Алдарт цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	
8	Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1439
9	Цалинтай ээж	701
10	Хүнс тэжээлийн дэмжлэг туслалцаа	280
11	Насны хишиг	742
12	Өрх толойлсон эх, эцгийн тэтгэмж	42
13	Ихэр хүүхдийн тэтгэмж	3
14	Олон нийтийн оролцоонд түшиглэлэсэн халамжийн үйлчилгээ	4
15	Хүүхдийн мөнгөн тэтгэмж	7176
<b>Нийгмийн халамжийн сангийн дүн</b>		<b>12180</b>

2023 оны 08 дугаар сарын хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд аймгийн хэмжээнд 49 өрхийн 280 гишүүнд олгож байна.

Ehalamj.mn системээр дамжуулан иргэдийн үйлчилгээг бүртгэн 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмжид 701 иргэний, жирэмсэн эхийн тэтгэмжид 142 иргэний тэтгэмжийг илгээсэн. 8 сард 7176 хүүхэд Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгосон.

2023 оны 08 сарын 17-ны байдлаар ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт, тусламжийг 81 иргэнд биечлэн үйлчилгээ үзүүлж, утсаар 40 ахмадад зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

**ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

**Мал аж ахуйн чиглэлээр:** Аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн “Өвөлжилт, хаваржилт болон ургац хураалтын бэлтгэл хангуулах тухай” 01 дүгээр албан

даалгавар, нэгдсэн төлөвлөгөөний дагуу малчдын түвшинд бэлтгэх өвс, тэжээлийн тооцоог гаргасан. Аймгийн хэмжээнд нийт 798 малчин өрхийн хонин толгойд шилжүүлснээр 715.1 мян.тол мал өвөлжих тооцоотой байна. Эдийн засгийн эргэлтэд 134.6 мян.толгой мал буюу одоогийн байгаа малын 21.2 хувийг оруулах тооцоотой байна. Нийт малын 75% нь дундаас дээш тарга хүчтэй байна. Малчдын түвшинд нийт малын 25%-ийг нэмэгдэл тэжээлээр тэжээхэд 10.2 мян.тн өвс, 1.7 мян,тн үйлдвэрийн тэжээл, 102 тн гар тэжээл, 644 тн хужир шүү шаардлагатай байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газраас ахмадын зөвлөх үйлчилгээнд 3 ахмад мал зүйч хамрагдсан бөгөөд малчдад чиглэсэн сургалт нөлөөллийн арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна.

### **Хоршоо, ЖДҮ, Ахуйн үйлчилгээний чиглэлээр:**

Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 2023 оны 8 дугаар сарын 19-ний байдлаар 71 зээлдэгчийн нийт үлдэгдэл 1.1 тэрбум төг байна. Үүнээс хэвийн зээл 3, хугацаа хэтэрсэн 10, хэвийн бус 1, эргэлзээтэй 1, муу зээл 56 байна.

Зээлийн ангилалыг сумдаар харуулбал:

Сүмбэр суманд 42 зээлдэгчийн нийт үлдэгдэл 821518.7 мян.төгрөг, /үүнээс хэвийн зээл 2, хугацаа хэтэрсэн 5, муу зээл 35 байна/.

Шивээговь суманд 21 зээлдэгчийн нийт үлдэгдэл 120609.6 мян.төгрөг, /үүнээс хугацаа хэтэрсэн 4, хэвийн бус 1, эргэлзээтэй 1 муу зээл 15 байна/.

Баянтал суманд 8 зээлдэгчийн нийт үлдэгдэл 173843.1 мян.төгрөг, /үүнээс хэвийн зээл 1, хугацаа хэтэрсэн 1, муу зээл 6 байна.

Сумын нэр	Зээлдэгчийн тоо	Авсан Зээл	Бодсон хүү	Тооцсон алданга	Төлбөл зохих дүн	Төлсөн дүн	Эцсийн үлдэгдэл
Сүмбэр	42	1'086'970.000	78'665.423	982'176	1'166'617.599	345'098.870	821'518.29
Шивээговь	21	180'500.000	10'707.100	2'526.395	193'733.495	73'123.874	120'609.621
Баянтал	8	191'500.000	18'419.651	8'648.745	218'568.396	44'725.258	173'843.138
	<b>71</b>	<b>1'458'970.000</b>	<b>107'792.174</b>	<b>12'157.316</b>	<b>1'578'919.490</b>	<b>462'948.002</b>	<b>1'115'971.488</b>

Сүмбэр сумын ЗДТГ нь ХААХҮХолбооноос Дундговь аймагт зохион байгуулагдсан "ХОРШООДЫН ШИНЭЧЛЭЛ-ХӨГЖЛИЙН ШИНЭ ЭХЛЭЛ" хөдөө аж ахуйн хоршоологчдын улсын зөвлөгөөнд 7 хоршооны 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцож, Дундговь аймгийн Гурвансайхан сумын "Давших зам" хоршооны үйл ажиллагаатай танилцаж туршлага солилцож, Эко тансаг гашуун болон Тэвшийн хажуу ус хоршоодууд өөрсдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ сурталчилсан.

Засгийн газрын 2020 оны 113 дугаар тогтоолоор батлагдсан “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, дамжуулан зээлдүүлэх, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын дагуу аймгийн Засаг даргын 2023 оны А/118 захирамжаар баталгаажсан нийт 448’000’000.00 үнийн дүнтэй 3 төслийн мэдээллийг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн мэдээллийн санд оруулж Жижиг дунд үйлдвэрийн газарт хүргүүлсэн. Үүнд: Эрчимжсэн мал аж ахуйн 250’000’000.00 төгрөгийн үнийн дүнтэй 1 төслийн барьцаа хөрөнгийн үнэлгээнээс шалтгаалан 240’000’000.00 төгрөгийн гэрээ, “Педим инсайт повер” ХХК-ийн 100’000’000.00 төгрөгийн үнийн дүнтэй “Төмс, хүнсний ногооны зоорь” төслийн барьцаа хөрөнгийн үнэлгээнээс шалтгаалж 60’000’000.00 төгрөгийн, “Очирмөнх Хайрхан” ХХК 98’000’000.00 төгрөгийн гэрээ байгуулж байна.

#### **Дэд хорооны шатны шалгаруулалтад хамрагдсан ААНБ -ын мэдээлэл**

<b>№</b>	<b>Харилцагчийн нэр</b>	<b>Үйл ажиллагааны төрөл</b>	<b>Зээлийн дүн</b>
1	“Очирмөнх Хайрхан” ХХК	Мах махан бүтээгдэхүүн болосруулах	98’000’000.00
2	“Педим инсайт повер”	Төмс, хүнсний ногоо зоорь	60’000’000.00
3	“Өрнөх Чойр” хоршоо	Эрчимжсэн мал аж ахуй	240’000’000.00
	<b>Нийт</b>		<b>398’000’000.00</b>

#### **Газар тариалангийн чиглэлээр:**

2023 оны 08 дугаар сарын 04-ний өдрөөс 08 дугаар сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд тариалалт хийсэн талбайн үзлэг, ургацын урьдчилсан баланс тооцох, өрхийн тариалалтыг дэмжих зорилгоор 2022, 2023 онд олгосон хүлэмжүүдийн ашиглалтыг хянах ажлуудыг зохион байгуулж байна.

Аймгийн дүнгээр нийт тариалсан талбай 68.48 га; /үүнээс төмс 21.02 га-д, хүнсний ногоо 32.51 га, малын тэжээл 11.9 га, жимс, жимсгэнэ 3.05 га/ тариалснаас ургац алдсан талбай 1.083 га, /үүнээс төмсний 0.13 га, хүнсний ногооны 0.953 га/ хураах талбай 67.39 га /үүнээс төмс 20.89 га, хүнсний ногоо 31.56 га, малын тэжээл 11.9 га, жимс, жимсгэнэ 3.05 га/ байна. Ургацын урьдчилсан балансаар 167.12 тн төмс, 268.253 тн хүнсний ногоо, 17.85 тн тэжээл хураан авахаар байна.

2022, 2023 онд олгосон нийт 85 хүлэмжийн ашиглалтыг тооцоход Баянтал сум 78%, Шивээговь сум 60% ашиглалттай, Сүмбэр сумын хүлэмжийн ашиглалтыг тооцох ажил эцэслээгүй байна.

08 дугаар сарын 18-ны байдлаар эрт ургацын 16.98 тн, 3 төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлээд байна.

**Хүнсний нөөцийн талаар:** Хүнсний нөөцийн бодит мэдээллийг 3 сумаас авч нэгтгэв. Үүнд: Аймгийн дүнгээр мах 22 тн буюу 10, гурил 34 тн буюу 30, сүү 3.8 тн буюу 1, төрөл бүрийн будаа 19 тн буюу 26, төмс 17 тн буюу 11, хүнсний ногоо 18 тн буюу 5, элсэн чихэр 6 тн

буюу 15, давс 6 тн буюу 19, савласан ус 18 тн буюу 1, өндөг 1 тн буюу 10, ургамлын тос 4.2 тн буюу 18 хоногийн нөөцтэй байна

### **ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

Говьсүмбэр аймгийн Засаг даргын 2023 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн А/215 дугаар захирамжийн дагуу тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих зөвшөөрлийн нээлттэй, дуудлага худалдааг угалз-1, цагаан зээр-25 толгойг 7 хэсэгт багцалж цахимаар 2023 оны 08 дугаар сарын 08-ны өдөр зохион байгууллаа.

Чойрын богд уул, Цоорхойн рашаан зэрэг газар болон зам дагуух түр буудаллах цэгүүд дэх 5 байрлалд байгаа нүхэн жорлонгуудад органик нэгдлийг задалж, лагийн хэмжээг багасгах, эвгүй үнэрийг арилгах бодис хийж, хөрс, орчны бохирдлыг бууруулах, ариутгал халдваргүйтгэлийн арга хэмжээ авч ажиллав. “Жорлонгоо өөрчилье” аяны хүрээнд иргэдэд байгальд ээлтэй бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах, ХААН, ХАС, ТӨРИЙН банкуудаар ногоон зээлд хамрагдах боломжтой болсон талаарх мэдээллийн цахимаар болон 5 иргэнд гарын авлага, холбогдох байгууллагуудын мэдээлэл өгсөн.

“Ундны усны аюулгүй байдлын төлөвлөгөөг батлах тухай” аймгийн ИТХ-ийн 2023 оны 08 дугаар сарын 04-ны өдрийн ээлжит 18 дугаар хуралдааны № 04 дүгээр тогтоолын хавсралтаар төлөвлөгөөг батлуулан төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж эхлээд байна.

Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар “Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд гүн өрмийн худаг гаргах, хашааны материал хүлээн авах ажлыг “Ус ундрах” ХХК гүйцэтгэсэн. Ажлын гүйцэтгэл 100 хувь улсын комисс 2 удаа ажиллаж хүлээн авсан.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх тур операторуудтай хамтран ажиллах, түншэлийн уулзалтын үр дүнд хамтран ажиллах гэрээ байгуулснаар Боржигин голомт жуулчны бааз ОХУ, Буриад, Хятад улсуудын 45 жуулчин болон дотоодын 1200 гаруй аялагч хүлээн авсан.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд тарьсан мод, ногоон байгууламж, мод үржүүлгийн тарьц суулгацын нөөцийн тооллого хийх ажлын хэсгийг 2023 оны 08 сарын 22-ны өдрийн А/238 дугаар захирамжаар байгуулсан. Тооллогын ажлын 2023 оны 09 сарын 01-ний өдрөөс 15-ны хооронд хийж гүйцэтгэнэ.

#### **Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:**

Барилга, хот байгуулалтын сайдын 2019 оны 34 дүгээр тушаалаар батлагдсан “Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын аргачилсан заавар”-ын дагуу Сүмбэр сумын хот тосгон, бусад суурин газарт 2023 оны 07 дугаар сарын 27-ны өдөр мониторингийн 10 цэгт хөрсний эрүүл ахуй, хүнд металлын бохирдлын судалгаа хийж, бохирдлын дээж авч лабораторийн шинжилгээнд хамруулах, бохирдлыг тодорхойлох судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторингийн аргаар үнэлэх ажлыг ГХГЗЗГазрын даргын 2015 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн А/105 тоот тушаалаар батлагдсан “Бэлчээрийн газрын өөрчлөлтийг фото мониторинг хийх аргачлал”-ын дагуу аймгийн хэмжээнд нийт 3 сумын 10 багт, 2023 оны 08 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд 48 цэгийг төлөөлүүлэн сонгож бэлчээрийн даац тодорхойлох хээрийн судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. 10 дугаар сарын 01-ний дотор газар, зохион байгуулалт, геофизи, зураг зүйн газарт хүргүүлнэ.

Сүмбэр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2023 оны 04 дүгээр тогтоолоор сумын 2023 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд нэмэлт тодотголоор 2 байршилд 0,5га газрыг төрийн байгууллагад олгохоор хэлэлцэн баталлаа.

Улс, орон нутгийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа барилга, байгууламжийн ажилд хяналт тавин ажилласан. Үүнд:

1. "Говьсүмбэр аймгийн 2000м<sup>3</sup> бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөх, шинэчлэх шинээр барих" төслийн ажлын гүйцэтгэл 80 хувьтай, гадна цахилгаан хангамжийн ажил 95 хувьтай хийгдэж байна.
2. “Боржигон чуулгын барилга” 1 дүгээр гүйцэтгэл 85 хувьтай
3. “Халуун усны барилга” Халуун усны барилгын ажил 55 хувтай
4. Аймгийн төвийн авто замын ажил 2,8км Авто замын 4 хэсэг ажлын гүйцэтгэл хэсэг тус бүр 60-90 хувийн гүйцэтгэлтэй хийгдэж байна.
5. Тээвэрчдийн өргөн чөлөө 0,36 км автозамын ажлын гүйцэтгэл 70 хувьтай
6. Тээвэрчдийн өргөн чөлөө гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэл 95 хувьтай
7. Төрийн банкны Шивээговь суман дах Тооцооны төвийн барилгын 100 хувьтай байна. Үүрэг даалгаврын биелэлтийн шатандаа явж байна.

**Худалдан авах ажиллагааны талаар:** Төсвийн ерөнхийлөн захирагчид 2023 онд нийт 8,279,947.0 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 26 бараа, ажил, үйлчилгээ худалдан авч хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс:

**Улсын төсвийн хөрөнгө оруултаар 4,194,800.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:

- Үнэлгээ хийгдэж байгаа төсөл арга хэмжээ – 1 / 85,000.0 мянган төгрөг/
- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ -1 / 4,109,800.0 мянган төгрөг/ Төлөвлөгөөний биелэлт 50 хувь.

**Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 1,023,869,4** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл арга хэмжээ төлөвлөгдсөнөөс:

- Тендерийн шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан төсөл арга 4/ 516,876.8 мянган төгрөг/
- Гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 3 / 506,992.6 мянган төгрөг/ Төлөвлөгөөний биелэлт 70 хувь.

**Аймгийн “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн хөрөнгөөр 2,451,959.1** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 14 төсөл арга хэмжээ төлөвлөснөөс тендерийн шалгаруулалтыг цахим хэлбэрээр зарласан төсөл арга хэмжээ – 3 / 1,300,000.0 мянган төгрөг/, гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ - 9 / 2,040,280.0 мянган төгрөг/, төлөвлөгөөний биелэлт 80 хувь.

**Аймгийн “Авто замын сан”-ийн хөрөнгөөр 440,616.5** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ –1 / 440,616.5 мянган төгрөг, Төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

**Аймгийн “Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал”-аар 28,702.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 28,702.0 мянган төгрөг, төлөвлөгөөний биелэлт 100 хувь.

**Аймгийн “Бусад хөрөнгө оруулалт”-аар 28,702.0** мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий 1 ажил төлөвлөснөөс, гэрээ байгуулах эрх олгосон төсөл арга хэмжээ – 1 / 100,000.0 мянган төгрөг, төлөвлөгөөний биелэлт 60 хувь

**Хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.2-т заасныг үндэслэн худалдан авах ажиллагаанд мөрдөх журмыг сонгон зарласан. Дараах худалдан авах ажиллагааг зарласан.**

- Нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зарласан - 13
- Харьцуулалтын аргаар - 9
- Зөвлөх үйлчилгээний тендер – 4

Аймагт 1994 оноос хойш хүүхдийн зуслангийн чиглэлээр ажиллаж байсан төрийн болон орон нутгийн өмчит хувьчлагдсан зуслангийн судалгааг маягтын дагуу гарган, аймгийн Аудитын газарт хүргүүлсэн.

Аймагт хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлыг хүлээн авах комисст ажиллан, дараах ажлуудыг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгч, бүртгэлд тусгахаар ажиллаж байна. Үүнд:

- ✓ Шивээговь сумын шинэ суурьшлын бүсэд худаг гаргуулах, ухаалаг систем суурилуулах ажил
- ✓ Баянтал суманд хийгдсэн ухаалаг худгийн систем суурилуулах ажил
- ✓ “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд усалгааны худаг гаргах, хашаа барих ажил
- ✓ Ногоон паспорт ухаалаг систем
- ✓ Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн хүрээнд өрхийн тариалан эрхлэлтийг дэмжих зорилгоор хүлэмж худалдах авах

Орон нутгийн түрээсийн орлогын төлөвлөгөө 8 дугаар сарын байдлаар 24.8 сая төгрөг байхаас гүйцэтгэл 23.0 сая төгрөг буюу 93 хувьтай байна.

Баянтал сумын ЗДТГ-тай гэрээ байгуулсан “Чойр хайрхан” ХХК түрээсийн орлогод 35.4 сая төг төвлөрүүлэхээс 6.0 сая төг төвлөрүүлсэн.

Сүмбэр сумын 2023 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх “Тоглоомын талбайн тохижилтыг сайжруулах, 4, 5, 6-р багийн халаалтын системийг сайжруулах ажил”-уудыг төрийн худалдан авах ажиллагааны цахим системээр дахин зарласан.

Сумын ИТХ-аар Орон нутгийн хөгжлийн санд нэмэлт өөрчлөлт орж Өлзийт суурьшлын бүсийн цахилгаан хангамжийг нэмэгдүүлэх, 6-р цэцэрлэгийн гал тогооны тоног төхөөрөмж худалдан

авах, 1 дүгээр сургуульд сурагчийн ширээ сандал худалдан авах ажлуудыг санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн.

Сүмбэр суманд Хаус хороолол хөгжүүлэх, иргэдийг орон сууцаар хангах, ая тохитой амьдрах орчин бий болгох зорилгоор Сүмбэр сумын 3-р багийн нутагт дэвсгэрт 32 айлын хаус хороолол барих төслийн нээлттэй сонгон шалгаруулалт гүйцэтгэгч орж ирээгүй тул урилгыг дахин нийтэлсэн.

Шивээговь сумын 2023 оны ОНХС-ийн хөрөнгөөр “Ойн зурваст ус нөөцлөх сав хийлгэж байршуулах ажил”, “Ойн зурваст усалгааны системийг шийдвэрлэх ажил”-ын үнэлгээний хороо хуралдаж, бичиг баримтын шаардлага хангасан компанитай гэрээ байгуулахаар ажиллаж байна. Мөн “Хогны машин худалдан авах” ГСАШГСЗДТГ/202304008 дугаартай ажил, “Илчлэг Шивээ ОНӨААТҮГ нүүрс тээврийн автомашин худалдан авах” ГСАШГСЗДТГ/202304010 ажлуудаар гэрээ байгуулж, хүлээн авахаар ажиллаж байна.

#### **Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газар:**

1. Золбин нохой муур устгах ажлыг Тохижилт-Сүмбэр ОНӨААТҮГ-тай хамтран 07 дугаар сарын 27-29-ны хооронд 2-р багийн Засаг дарга хяналт тавин зохион байгуулж нийт 221 нохой, 37 муур устгасан.

2. Шарилж, зэрлэг ургамал устгах ажлын хүрээнд сумын Засаг даргын захирамж гарган ажлын хэсэг байгуулан “ Шарилжгүй Сүмбэр” 1 сарын аяныг зохион байгуулахаар удирдамж гарган батлаж албан байгууллага, аж ахуй нэгжүүд, айл өрхөд хүргүүлэхийн зэрэгцээ цахим орчинд урилага гаргаж байна.

#### **Шивээговь сумын Засаг даргын Тамгын газар:**

Сумын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл ажил эхэллээ.Сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/110 дугаар захирамжаар 2023-2024 оны өвөлжилт хаваржилтын бэлтгэл хангуулах ажлын төлөвлөгөөг батлуулан, ажлын хэсгийн гишүүд 2023 оны 08 дугаар сарын 16-ны өдөр хуралдан ажлыг чанартай зохион байгуулах тал дээр анхааран, аж ахуй нэгж, албан байгууллага айл өрх, хөдөөгийн багийн малчид мал бүхий иргэдийг өвөлжилтийн бэлтгэл ажлыг чанартай хангуулан ажиллах талаар үүрэг болголоо. Мөн сумын аюулгүйн нөөцийг бүрдүүлэх ажлын бэлтгэл эхлэв.

#### **Баянтал сумын Засаг даргын Тамгын газар:**

Сумын өвөлжилтийн бэлтгэл ажил хангах төлөвлөгөө, ажлын хэсгийн сумын Засаг даргын захирамжаар байгуулж, аж ахуй нэгжүүдэд хүргүүлээд байна.

ОХУ-аас БНХАУ-лстай хийн дамжуулах хоолойн маршрутын дагуу Баянтал суманд ачилт буулгалтын талбай байгуулах ажлын хэсэг Баянтал суманд ажиллан судалгаа хийж, харилцан мэдээлэл солилцож, шаардлагатай мэдээллийг өгсөн.

Сумын төвд Цаг уурын хяналтын бүс байгуулах ажилд зориулж 400 уртааш метр төмөр хайсан хашаа барьсан.

Иргэн Д.Мөнх-Эрдэнэтэй байгуулсан Төв хогийн цэгийг Ландфилл аргаар булшлах гэрээт ажил бүрэн хийгдэж дууссан. Тус ажлыг гүйцэтгэгч тал 2023 оны 08 дугаар сарын 10-ны өдөр бүрэн хийж дуусган захиалагч талд хүлээлгэж өгөхөөр гэрээ байгуулан ажилласан.

### **ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**